AIM
ملتقى الاستثمار السنوي
Annual Investment Meeting

Annual Investment Meeting

World's Investment Leading Platform

8 - 10 May 2023
Abu Dhabi, United Arab Emirates

“Инновацийг дэмжих, мэдлэг мэдээлэл солилцох мөн дэвшилтэт технологид суурилсан шинэ боломжуудыг ашиглах нь АНЭУ-ын ирээдүйн хөгжлийн алсын хараа, стратегийн үндсэн чиглэл юм.”

ШАХ МОХАММЕД БИН РАШИД АЛЬ МАКТУМ

АРАБЫН НЭГДСЭН ЭМИРАТ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

АБДУЛА БИН ТОУГ АЛ МАРРИ

АРАБЫН НЭГДСЭН ЭМИРАТ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН САЙД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧУУЛГА УУЛЗАЛТАД ОРОЛЦОХЫН АЧ ХОЛБОГДОЛ

1. Дэлхийн хамгийн том хөрөнгө оруулалтын чуулга уулзалтад төр, хувийн хэвшлийн төлөөллийг манлайлан улс орноо төлөөлж оролцох
2. Оролцогч бусад улс орнуудын Засгийн газрын төлөөлөгчидтэй хийх хоёр талт уулзалтууд (G2G Meetings)
3. Томоохон хөрөнгө оруулагчидтай хийх хоёр талт уулзалтууд (G2B Meetings)
4. Гадаадын хөрөнгө оруулалтын агентлагаас хөрөнгө оруулалт татах чиглэлээр хэрэгжүүлж буй ажлуудаа танилцуулах боломж

ШАХ МОХАММЕД БИН РАШИД АЛЬ МАКТУМ

АРАБЫН НЭГДСЭН ЭМИРАТ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧУУЛГА УУЛЗАЛТАД ОРОЛЦОХЫН АЧ ХОЛБОГДОЛ

5 Монгол улсад хөрөнгө оруулалт шаардлагатай голлох салбарууд болон томоохон төслүүдийг танилцуулах боломж

6 Монголоос очих төлөөллийг ахласан сайд сайд нарын уулзалтад оролцох, танилцуулга хийх, үг хэлэх

7 Хөрөнгө оруулалтын чуулга уулзалтын (AIM) хэвлэл, мэдээллийн сувгуудаар Монголын тухай танилцуулга хийх

8 Хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр бусад улс орнуудад хэрэгжүүлж буй бодлого, сайн туршлагаас суралцах



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧУУЛГА УУЛЗАЛТАД ОРОЛЦОХЫН АЧ ХОЛБОГДОЛ

9 Монгол улсад хөрөнгө оруулах боломж, хөрөнгө оруулалтын бодлогын талаар хөрөнгө оруулагчдад танилцуулах

10 Гадаадын хөрөнгө оруулалтын агентлаг болон холбогдох хүний нөөцийг чадавхжуулах сургалт, семинар авах г.м

AIM 2022- ОНЦЛОХ АМЖИЛТ

11,593
Нийт оролцогч

174
Төлөөлөн оролцсон улс

439
Үзэсгэлэнд оролцогчид мөн үзэсгэлэнд хамтран оролцсон **61** орон

144
Стартап нийт **47** орноос

38
Хөрөнгө оруулагчдын төвд оролцсон байгууллагууд

3843
Хөрөнгө оруулагчдын төв дэх G2G/G2B/B2B уулзалтууд

13
Оролцогч орны хөрөнгө оруулалт татах танилцуулга

65
Төрийн өндөр албан тушаалтан
(Төрийн тэргүүн, сайд , дэд сайд, хотын захирагч болон олон улсын байгууллагын төлөөлөгчид)

369
Илтгэгч

6
Санамж бичигт гарын үсэг зурсан

70+
Уулзалт, хуралдаан

12
Сургалт, Семинар

82
Жижиг, дунд үйлдвэрлэгч

AIM ОРОЛЦОГЧДЫН ТАНИЛЦУУЛГА

AIM нь хөрөнгө оруулалт татахтай холбоотой хамгийн сүүлийн үеийн мэдлэг, мэдээлэл солилцох, стратегийн чиг хандлагыг тодорхойлох хамгийн том хөрөнгө оруулалтын чуулга уулзалт бөгөөд томоохон корпорацуудын удирдлага, бодлого тодорхойлогчид, бизнес эрхлэгчид, бүс нутаг болон олон улсын хөрөнгө оруулагчид, ЖДҮ эрхлэгчид, эрдэмтэн судлаачид болон салбар салбарын мэргэжилтнүүд нэг дор цугладгаараа онцлогтой.

- Засгийн газар болон яамдууд
- Багцын хөрөнгө оруулалт
- Даатгал, эрсдэл, зээлийн үнэлгээний компаниуд
- Олон улсын хөрөнгө оруулалтын байгууллагууд
- Эдийн засгийн институт ба холбоод
- ЖДҮ-ийн үндэсний зөвлөл, хөтөлбөрүүд
- ЖДҮ-ийн санхүүжилтийн институтууд
- Гарааны бизнес, инкубатор, тусгай хөтөлбөрүүд
- Ухаалаг хотын шийдэл нэвтрүүлэгчид
- Инновацийн паркууд
- Хот хөгжүүлэгчид
- Хувийн өмч, анжел хөрөнгө оруулагчид, венчур капиталистууд
- Технологийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд
- Банк санхүүгийн байгууллагууд
- Тэтгэвэр, хөрөнгө оруулалтын сан, гэр бүлийн сан
- Дипломат төлөөлөгчийн газар
- Худалдаа аж үйлдвэрийн танхимуудын бизнесийн зөвлөл
- Эдийн засгийн тусгай бүсүүд
- Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагууд
- Бүс нутгийн удирдлагын хэлтэс
- Олон улсын болон бүс нутгийн байгууллага

AIM БҮС НУТГИЙН САЛБАР БАЙГУУЛЛАГУУД

Дэлхий нийтийн хэмжээнд эдийн засгийн өсөлтийг хангах боломжуудыг бий болгох зорилгоор AIM өөрийн бүс нутгийн салбар байгууллагуудаа байгуулсан билээ. Тус салбар нэгжүүдээр дамжуулан бүс нутгийн эдийн засгийн чадавх, давуу талыг онцлох, бизнесийн орчныг судлах үндсэн зорилготой юм. Түүнчлэн эдгээр салбар нэгжүүд бүс нутгийн түвшинд авч хэрэгжүүлж буй хүчин чармайлтуудыг дэмжих, улс орнуудын эдийн засгийн хөгжлийн ялгааг ойртуулахад туслах үр дүнтэй платформ юм. AIM мөн бүс нутгуудад тулгарч буй цаг үеийн томоохон асуудлуудыг хэлэлцэх, цар тахлын дараах бүс нутгийн эдийн засгийг илүү хүчтэй, илүү тэсвэртэй болгоход туслах бат бөх түншлэлийг бий болгох, хөрөнгө оруулалтын шинэ боломжуудыг эрэлхийлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

AIM Латин Америк



AIM Европ



AIM Хятад

AIM Ази



AIM Африк

Голлох салбарууд

12 дахь удаагийн хөрөнгө оруулалтын чуулга уулзалт нь дараах салбаруудад гол анхаарлаа хандуулахаар ажиллаж байна.

- Дэд бүтэц
- Технологи
- Хөдөө аж ахуй
- Тээвэр ба ложистик
- Эрчим хүч
- Эрүүл мэнд
- Аялал жуулчлал
- Санхүү
- Үйлдвэрлэл
- Боловсрол

AIM ХӨТӨЛБӨР

1.

Чуулганы өмнөх семинарууд

Дэлхийн өнцөг булан бүрээс салбартаа тэргүүлэх, нэр хүндтэй мэргэжилтнүүд интерактив сургалт, семинар явуулдаг. Энэхүү семинар нь оролцогчдын туршлагыг баяжуулахаас гадна, хөрөнгө оруулалт татах ашигтай боломжуудыг бий болгох зорилгоор тусгайлан зохион байгуулагддагаараа онцлогтой.

2.

Бага хурал

Мэргэжилтнүүдийн ойлголт, шилдэг туршлага, хөрөнгө оруулалтын оновчтой бодлогыг оролцогчидтой хуваалцдаг. Уулзалтаар хөрөнгө оруулалтын нийгэмлэгийн удирдагчид болон мэргэжилтнүүд AIM сангийн таван багана тус бүрийн холбогдох сэдвүүдийг судлах хэлэлцүүлгийг удирдан явуулдаг.

3.

Нээлтийн ёслол

Тухайн жилийн чуулга уулзалтын өнгө аясыг тодорхойлдог томоохон арга хэмжээ бол нээлтийн ёслол юм. АНЭУ-ын төрийн тэргүүн, өндөр дээд түвшний албан тушаалтнууд албан ёсоор нээлтийн ажиллагааг эхлүүлдэг. Энэхүү үйл ажиллагаанд дэлхийн нэр хүндтэй удирдагчид, нөлөө бүхий хөрөнгө оруулагчид, хөрөнгө оруулалтын шинжээчид, улс орнуудын төлөөлөгчид оролцдог.

4.

Хөрөнгө оруулалтын дугуй ширээний уулзалт

Энэхүү арга хэмжээний гол зорилго нь засгийн газар болон хөрөнгө оруулагчдын хэрэгцээ, шаардлагад нийцсэн хөрөнгө оруулалтын нөхцлийг хэлэлцэх боломжийг талуудад олгох юм. Яриа хэлэлцээрийн төгсгөлд талуудын шаардлагад нийцсэн хөрөнгө оруулалтын загвар, нөхцлийг тохирдог.

5.

Хөрөнгө оруулалт чиглүүлэх бүс

Хотын захиргаа, хотууд болон улс орнууд өөрсдийн хөрөнгө оруулалтын боломжийг сурталчлах, тухайн сурталчилж буй бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт авах гол салбаруудыг танилцуулах боломжтой.

6.

Олон улсын үзэсгэлэн

Үүнд улс орон, бүс нутгийнхаа эдийн засгийн өсөлтийг хангах зорилгоор цугларсан улс орнууд, ухаалаг хотын шийдэл нэвтрүүлэгчид, гарааны компаниуд, ЖДҮ эрхлэгчид, хөрөнгө оруулалтын боломжууд багтдаг.



7. Бүс нутгийн төвлөрсөн хуралдаанууд

Эдгээр уулзалт, хуралдаанууд нь тухайн бүс нутгийн эдийн засгийн орчны талаар голчлон хэлэлцдэг бөгөөд бүс нутгийн хэмжээнд тулгарч буй хүндрэл, бэрхшээл түүнчлэн бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд эдийн засгийн өсөлтийг хангах ямар боломжууд байгаа талаар мэдээлэл солилцон ярилцдаг.

8. Хөрөнгө оруулагчдын төв

Засгийн газрын албан ёсны төлөөлөгч нар томоохон хөрөнгө оруулалтын байгууллага, хөрөнгө оруулалтын корпораци, хөгжлийн банк, төрийн баялгийн сан, багцын хөрөнгө оруулагчдын төлөөлөлтэй албан ёсоор уулзаж, дэлхийн хэмжээнд хөрөнгө оруулалтын түншлэл, хамтын ажиллагааны талаар ярилцах онцгой бүс юм.

9. Хөрөнгө оруулалтын шагнал

GALA оройн зоогийн үеэр нэр хүнд бүхий дэлхийн шилдэг хөрөнгө оруулалтыг дэмжигч агентлагийг шалгаруулдаг. Тухайн улсын томоохон, үр өгөөжтэй хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлж, улмаар эдийн засгийн өсөлт, зах зээлийн хөгжилд хувь нэмрээ оруулсан амжилтыг үнэлж, бүс нутаг бүрийн шилдэг ГШХО төслүүдэд шагнал гардуулдаг.

10. Startup илтгэлийн тэмцээн

Сонгогдсон гарааны бизнес эрхлэгчид эрсдэл, шинэ бизнесийн санаа, технологи, бизнесийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн шүүгчдийн бүрэлдэхүүнд өөрсдийн төслийг танилцуулах эрхтэй болно. Ялагч нь салбарын мэргэжилтнүүдтэй туршлага хуваалцах, зөвлөгөө мэдээлэл авах буюу менторын харилцаа үүсгэх боломжтой бөгөөд ингэснээр санхүүжилт авах боломж үнэмлэхүй нэмэгдэнэ.



11. GALA Dinner

Хөрөнгө оруулалтын шагнал гардуулах ёслолын ажиллагаанд зориулан дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн зочдод зориулсан оройн зоог. Тухайн оройн зоог нь нэтворкинг хийх, гол үйлчлүүлэгчид цагийг зугаатай өнгөрөөх боломжоор хангадаг.

12. Хоёр талт уулзалтуud

Хоёр талт уулзалтуудад улсуудын засгийн газрын хоорондох (G2G), засгийн газар бизнес хоорондын (G2B) болон компани хоорондын (B2B) уулзалтууд багтдаг; Үр өгөөжтэй уулзалт хийж, цаашдын хамтын ажиллагааны чиглэлээ тодорхойлох боломж олгодог.

13. Бусад хөтөлбөр

Хөрөнгө оруулалтын чуулга уулзалтын хамрах хүрээтэй холбоотой, агуулга, танилцуулгын хувьд түүний үзэл санаа, чиг үүрэг, зорилгод нийцсэн, хамтран зохион байгуулдаг арга хэмжээг дэмждэг. Дагалдах арга хэмжээг AIM зохион байгуулж, энэхүү ажлыг зохион байгуулах хороо хариуцдаг ба тус арга хэмжээний агуулга, илтгэгчийг зөвхөн AIM энэ хороо л хариуцдаг.

Яагаад Хөрөнгө Оруулалтын Чуулга Уулзалтад оролцох хэрэгтэй вэ?

БОЛОМЖ НЭЭХ

170 гаруй орны 15,000 гаруй оролцогчидтой AIM Global нь **засгийн газар, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдэд** төрөл бүрийн улс орны хөрөнгө оруулалтын боломж, бизнесийн орчныг сурталчлах зорилгоор өөр өөр төрлийн олон оролцогчидтой харилцах боломжийг олгодог.

СУРАЛЦАХ

AIM Global платформ нь олон зуун үзэсгэлэн гаргагчид, олон тооны оролцогчид, нэр хүндтэй хүмүүсийг татдаг бөгөөд энэ нь бизнес эрхлэгчдэд сүлжээний янз бүрийн арга хэмжээгээр дамжуулан дэлхийн өнцөг булан бүрээс хамтран ажилладаг аж ахуйн нэгжүүд болон гол шийдвэр гаргагчидтай харилцах, санал бодлоо солилцох боломжийг олгодог.

НЭТВОРКИНГ

Дэлхийн зах зээл дэх хамгийн сүүлийн үеийн технологи, хөрөнгө оруулалтын чиг хандлагыг зөвхөн тухайн арга хэмжээний нэр хүндтэй илтгэгчдийн жагсаалтаар бус, мөн тохиолдлоор бий болсон шинэ сүлжээгээр дамжуулан хийх.

ХАМТЫН АЖИЛЛАГАА

AIM Global-ын зорилго бол оролцогчдын дунд урт хугацааны хамтын ажиллагаа, түншлэлийг бий болгох явдал юм. Олон жилийн туршид AIM нь бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчид, засгийн газруудын хооронд харилцан өсөлтийг бий болгоход шаардлагатай платформоор хангах замаар амжилтанд хүрсэн.

ТАНИЛЦУУЛАГА

AIM Global-ын санал болгож буй төрөл бүрийн боломжуудаар дамжуулан хөрөнгө оруулагчид болон боломжит бизнесийн түншүүдэд хөрөнгө оруулалтын боломжууд, үр дүнтэй санаанууд болон хэрэгжих боломжтой төслүүдээ танилцуулах боломжтой.

Annual Investment Meeting

aimcongress.com | info@aimcongress.com

Organised by:

STRATEGIC
EXHIBITIONS & CONFERENCES